



Зөвлөмжийн Цуврал

ЗЦ139-11

Нэмэлт, өөрчлөлт 1 (2)

Өдөр - VFR аэродром ашиглалт

2016 оны 4 сарын 26

Ерөнхий зүйл

ИНЕГ-ын АС (АС) нь холбогдох ИНД-ийг дагаж мөрдүүлэх зорилгоор Даргын зөвшөөрсөн стандарт, практик, журмын талаарх мэдээллийг агуулдаг.

Даргад танилцуулах нийцлийн бусад аргыг ч анхаарч үзэх бөгөөд шинээр стандарт, практик, журам хүлээн зөвшөөрөгдөхөд холбогдох АС-д нь нэмж оруулна.

Түүнчлэн, энэхүү АС нь дүрмийн шаардлагыг хангах зааварчилгаа материалыг агуулна. Зааварчилгаа материал нь хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрт тооцогдохгүй.

Зорилго

Энэ АС нь өдөр-VFR аэродром төлөвлөлттэй холбогдуулан ИНД-139-ийн дагуу аэродром ашиглахад тавигдах шаардлагыг хангаж байгааг харуулах эрх бүхий байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн аргаар хангана.

Зориулалт

Энэ АС MCTOW нь 5700 кг, эсхүл түүнээс доош жинтэй нисэх онгоцоор үйл ажиллагаа эрхлэгчид зориулан өдрийн цагаар VFR-аар агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхэд зориулагдсан болно.

Холбогдох дүрмүүд

Энэ АС нь ялангуяа ИНД-139, Е Бүлэг, *Аэродромын ашиглалт*, 139.305 *Аэродромын ашиглалт- Агаарын тээврийн нисэх онгоц*-той холбоотой.

Өөрчлөлтийн тэмдэглэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

ИНД-139-ийг монгол, англи хэл дээр боловсруулсан болно. Эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хувилбартай харьцуулна.

ЗЦ 139-11-г NZ 139-11-ийн 2007 оны 04 сарын 27-ны өөрчлөлт 2-т үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

БУУЛТЫН АЭРОДРОМЫГ ӨДРИЙН ЦАГААР VFR-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАХ	3
1 Зорилго	3
2 Өдөр-VFR аэродром төлөвлөлт	3
3 Төлөвлөлтийн нийцэл	3
4 Аэродром төлөвлөлт болон нисэх онгоцны үзүүлэлт	4

БУУЛТЫН АЭРОДРОМЫГ ӨДРИЙН ЦАГААР VFR-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАХ

1 Зорилго

1.1 Энэ АС нь дараах чиглэлээр тайлбар ба зааварчилгаа өгнө:

- (a) аэродром төлөвлөлт;
- (b) нисэх онгоцны үзүүлэлт болон аэродром төлөвлөлтийн уялдаа холбоо; болон
- (c) аэродром төлөвлөлтийн стандартыг бүрэн хангаагүй аэродромыг үргэлжлүүлэн ашиглах.

2 Өдөр-VFR аэродром төлөвлөлт

2.1 АС139-7 Аэродром төлөвлөлт нь агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх МСТOW нь 5700кг, эсхүл түүнээс доош жинтэй нисэх онгоц ашиглах Даргын хүлээн зөвшөөрөхүйц төлөвлөлтийн стандартыг агуулна.

АС-ын хамгийн сүүлчийн хувилбарыг үргэлж ашигла, дараагийн цуврал бүр нь цагаан толгойн дарааллын дагуу дагавар үсэгтэй байна.

2.2 Монгол Улс нь өдөр-VFR аэродромын стандартыг боловсруулсан бөгөөд алслагдсан бүс нутагт олон жилийн хугацаанд ховор хийгддэг агаарын тээврийн үйл ажиллагаанд ашигладаг VFR аэродромд хэрэгжүүлж байна. Эдгээр аэродромыг ашигладаг нисэх онгоцыг аэродромтой холбоотой сургалт шалгалтын горимд хамрагддаг мэргэжлийн нисгэгч жолооддог.

2.3 Аэродромын стандарт нь гол төлөв тухайн аэродромыг ашиглах хамгийн том, эсхүл хамгийн чухал лавлах нисэх онгоцонд суурилдаг. Өдөр-VFR ХБЗ болон ХБЗ-ны талбайн өргөний үзүүлэлт нь лавлах нисэх онгоцны дугуй болон далавчны урттай холбоотой. ХБЗ нь хөөрөлтийн өндөр авах, ойртолт үйлдэх үед байгууламжаас ангид байхын тулд хажуугийн саадыг хязгаарлах гадаргууг тодорхойлсон байдаг. Энэ нь аливаа саад тухайн аэродромын үр дүнтэй ашиглалтыг хязгаарлахгүй, эсхүл аюулгүй байдалд аюул учруулахгүй байхыг бататгадаг.

2.4 Аэродромын стандартын зорилго нь лавлах/reference нисэх онгоцыг бүрэн хүчин чадлаар нь аюулгүй ажиллуулах боломжийг бүрдүүлэх явдал юм. ХБЗ-ны шаардлагатай урт нь нисэх онгоцны үзүүлэлтийн бүтээгдэхүүн бөгөөд лавлах нисэх онгоцны шаардлагад нийцүүлэх хэрэгтэй.

3 Төлөвлөлтийн нийцэл

3.1 Өдрийн-VFR агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглах аливаа аэродром нь АС139-7 МСТOW нь 5700, эсхүл түүнээс доош жинтэй нисэх онгоцны аэродром төлөвлөлт"-д заасан төлөвлөлтийн минимум үзүүлэлтийн шаардлагыг хангах ёстой. Аэродром төлөвлөлтийн үзүүлэлт нь үйл ажиллагааны хязгаарлалтыг тогтоохыг зорьдоггүй ч, аэродром төлөвлөлтийн минимум шаардлагыг тогтооно.

3.2 Зайлуулж болохгүй байгууламж байгаагаас шалтгаалж аэродром төлөвлөлтийн үзүүлэлтийг бүрэн хангаж чадахгүй ч өдрийн цагаар VFR-аар

агаарын тээврийн үйл ажиллагаанд удаан хугацаанд ашиглагдаж байгаа аэродром олон байдаг. Эдгээр аэродром нь нисгэгчийн тусгай сургалт, дадлага, гадаргуугийн салхины нөхцөл болон бусад нөхцөл дэх аэродром ашиглалтын хязгаарлалтыг хэрэгжүүлдэг тусгай үйл ажиллагаа эрхлэгч аюулгүй үйл ажиллагаа явуулдаг түүхтэй.

3.3 Аэродром АС139-7-гийн төлөвлөлтийн үзүүлэлтийг бүрэн хангаж чадахгүй тохиолдолд нисэх онгоцоор үйл ажиллагаа эрхлэгч дараах арга хэмжээг авна:

- (a) аюулгүй байдлын дүйцэх түвшинг хадгалах үйл ажиллагааны нөхцөл болон хязгаарлалтыг тогтоох; болон
- (b) үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисгэгчид тогтоосон нөхцөл болон хязгаарлалтын баримтжуулах.


4 Аэродром төлөвлөлт болон нисэх онгоцны үзүүлэлт

4.1 Нисэх онгоцны нислэгийн зааварт тусгасан үзүүлэлтийн зөвшөөрөгдсөн өгөгдлийг иргэний нисэхийн эрх зүйн баримт бичигт заасан нисэх онгоцны үзүүлэлтийн үйл ажиллагааны хязгаарлалтад нийцэж байгааг тогтооход ашиглана.


4.2 Аэродром ашиглалттай холбоотой гүйцэтгэлийн хязгаарлалтыг хөөрөх, буух болон хөөрөлтийн үеийн нислэгийн замд байгаа саадыг давах зайд хэрэглэнэ.

4.3 Хөөрөлт ба өндөр авалт:

- (a) ХБЗ-ны хөөрөлтийн үр дүнтэй ашиглалтын урттай холбоотой аэродром төлөвлөлтийн хөөрөлтийн өндөр авах гадаргуу нь тогтоосон саадыг давах зайн шаардлагыг дагаж мөрдөх, нисэх онгоцоор үйл ажиллагаа эрхлэгчийг хөөрөлтийн максимум жинг тооцоолох энгийн системээр хангана. Хэрэв саад нь хөөрөлтийн өндөр авах гадаргууг нэвтэлж байвал ХБЗ-ны хөөрөлтийн үр дүнтэй ашиглалтын уртыг 1:20-оос тохирох хэмжээнд хүртэл бууруулна. Зураг 1 болон 2-т энэ талаарх энгийн зургийг харуулав.




Зураг 1. Саадаас чөлөөлөгдсөн хөөрөлтийн гадаргуун төлөвлөлт



Зураг 2. Саад бүхий өндөр авалтын гадаргуун төлөвлөлт

- (b) Хөөрөлт болон өндөр авалтын гүйцэтгэлийн шаардлагын нийцлийг тооцоолох илүү нарийвчилсан арга нь дараах зүйлсийг тодорхойлох:
- (i) аэродромын түвшнээс дээш байгаа эрсдэлтэй саадын өндөр; болон
 - (ii) хөөрөлтийн боломжит зайн төгсгөлөөс эрсдэлтэй саад хүртэлх зай; болон
 - (iii) шаардлагатай нөөцөөр саадыг чөлөөлөх зорилгоор нисэх онгоцны хөөрөлтийн жин болон конфигурацийг тооцоолохдоо тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт байгаа гүйцэтгэлийн өгөгдлийг ашиглах; эсхүл
 - (iv) ашиглах боломжтой гүйцэтгэлийн өгөгдөл байхгүй тохиолдолд саадаас чөлөөлөх дүрсэлсэн журам болон хязгаарлалтыг тогтооно.

Энэ нь илүү нарийн тооцооллыг агуулдаг боловч ачаалал хэт нэмэгдсэн тохиолдолд хөөрөлтийн тохиромжтой зай ашиглан тооцоолох нь нисэх онгоцоор үйл ажиллагаа эрхлэгчид ашигтай байх талтай. Зураг 3-т харуулав.




Зураг 3. Өндөр авалтын саадаас чөлөөлөгдөх шаардлага

Тайлбар:

1. Саадыг давах зай нь босоо чиглэлд хамгийн багадаа 15м (50 ft)+0,025D*, эсхүл хөндлөн чиглэлд 30м (100ft) + 0.10D байна. *D=ХБЗ-ны хөөрөлтийн боломжит зайнаас цааш орших зай.
2. Эргэлттэй нислэгийн замыг зөвшөөрөх боловч олон хөдөлгүүрт нисэх онгоцны хувьд банк нь 15°–аасс хэтрэхгүй байна.

4.4 Буулт:

- (a) 1:20-ийн аэродромын төлөвлөлтийн ойртолтын гадаргуу нь нисэх онгоц нислэгийн зааврын дагуу хэвийн ойртолт үйлдэхэд саадыг давах зайгаар хангах, ХБЗ дээр нэрлэсэн газардах цэгээр хангана. Саад нь ойртолтын гадаргууг нэвтэрч байвал босгыг шилжүүлэх болон ХБЗ-ны буултын боломжит зайг багасгах арга хэмжээ авна. Зураг 4 болон 5-д саадгүй болон саадтай ойртолтын гадаргуун төлөвлөлтийг үзүүлэв.



Зураг 4. Аэродромын ойртолтын гадаргуун төлөвлөлт

- (b) Хэрэв саад нь буултын үр дүнтэй ашиглалтын уртын 1:20 харьцааг багасгахаар бол нисэх онгоцоор үйл ажиллагаа эрхлэгч саадаас зайлсхийх, шилжүүлсэн босгыг ашиглах гэхээс илүүтэйгээр ХБЗ-ны буултын боломжит зайг бүрэн ашиглахыг хүсвэл нисэх онгоцны нислэгийн зааврын хязгаарлалтын хүрээнд ойртолтын өнцгийг илүү огцом болгох үүднээс ойртолт болон буултын техникт өөрчлөлт тогтоож болно.

Зураг

6-д

үзүүлэв.

Буултын шилжүүлсэн босго

Ойртолтын гадаргуун төлөвлөлт
Ойртолтын гадаргуун хувилбар

Зураг 5. Аэродромын ойртолтын гадаргуун төлөвлөлт-саадтай

Буултын шилжүүлсэн
босго

